



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/525

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гар бөмбөгийн спортыг хөгжүүлэх зорилгоор “Арвайхээр лиг” аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 9,000,000 (есөн сая) төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2.Дээрх 9,000,000 (есөн сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ